



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024. 04. 29 № А - 1/1786  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Тодруулгын хариу хүргүүлэх  
тухай

Тус газраас зарласан “Боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүн ерөнхий гэрээгээр худалдан авах” ТХААГ/20240502001 дугаартай төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгох тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга авах хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан захиалагчаас ирүүлсэн дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
Оросын Холбооны Улсын Украинд явуулж буй байлдааны үйл ажиллагаа, Ойрхи дорнодод үүсээд буй хурцадмал байдлаас үүдсэн шатах тослох материалын үнийн өсөлт (4 сарын 12-ны байдлаар Брент маркийн газрын тосны Фьючерс хэлцлийн нэг торхны үнэ 90.08 ам.доллар), Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлээс шалтгаалан бүтээгдэхүүн, түүхий эдийг захиалагч сургууль нэг бүрт хүргэж, хүлээлгэж өгөх тээврийн зардал болон ажиллах хүчиний зардал өмнөх жилийн түвшнээс өссөн тул төмсний багцын нэгж дээд үнийн дээд хязгаарт өөрчлөлт оруулах, тухайн жилийн 1-2 дугаар сард үнийн тохируулга хийж байх зохицуулалтыг тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжтой эсэх.	Захиалагч Боловсролын ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01/1745 дугаартай албан бичгээр “Угааж цэвэрлэсэн төмс 10кг”-ын нэгж үнийн дээд хязгаарт өөрчлөлт оруулж ирүүлсэн тул тендер шалгаруулалтын баримт бичигт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.
Хүнсний ногооны захиалагчийг дүүрэг бүрээр бүсчлэх замаар тээврийн зайд болон түүнд зарцуулах цаг хугацааг багасгаж, зардлыг бууруулах боломжтой эсэх.	Ерөнхий гэрээ байгуулсан оролцогчийн хувьд үнийн тохируулга хийх боломж нээлттэй бөгөөд ерөнхий гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу тохируулгыг хийнэ.

Тухайн тендер шалгаруулалт нь тендер шалгаруулалтын баримт бичгийн 33.1-д “Ерөнхий гэрээний хүчинтэй байх хугацаанд аж ахуй эрхлэгчээс бичгээр ирүүлсэн хүсэлтэд үндэслэн шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний тендер шалгаруулалтыг тодорхой хугацаанд

1324024809

	зохион байгуулах бол тухайн ерөнхий гэрээг анх зарласан тендер шалгаруулалтын баримт бичгийн хүрээнд зохион байгуулж, шалгарсан оролцогчтой ерөнхий гэрээний хүчинтэй байх үлдсэн хугацаагаар гэрээ байгуулж, цахим дэлгүүрт бүртгэнэ” гэж заасны дагуу жагсаалт нэмэх зорилготой зарласан тендер шалгаруулалт тул тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжгүй байна.
--	--

Захиалагчаас 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 01/1745 дугаартай албан бичгээр Багц № 16: Угааж цэвэрлэсэн төмс-10кг-ын нэгж үнийн дээд хязгаарт өөрчлөлт оруулж ирсэн тул тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

1. ТШЗ 2.1 Худалдан авах бараа, үйлчилгээний нэгж үнийн дээд хязгаар дараах байдалтай байна. Үүнд:

№	Багцын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ, дээд хязгаар /төгрөг/
16.	Багц № 16: Угааж цэвэрлэсэн төмс-10кг	Ширхэг	19,500

